

ХЯТАДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖИЛ 2011-2015 ОНД*Шү Кеси **

Арга зам ба зорилт: Хятад улс нүүрснээс хамааралтай байдлаа бууруулж, эрчим хүчний эх үүсвэрийн төрлийг нэмэгдүүлж, хэрэглээний үр дүнг сайжруулах талаар анхаарах болно.

Хятадын өнөөгийн ерөнхий нөхцөл, олон улсын чиг хандлага, 2011-2015 оны дотоодын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн Хятадын Үндэсний Эрчим хүчний удирдах газрын (ҮЭХУГ) Хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн захирал Жян Бин 2015 он гэхэд Хятад улс эрчим хүчний үндсэн хэрэглээ болсон нүүрсний хэрэглээг 4-4,2 тэрбум тн-ы хооронд байлгах болно гэж нотолсон байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Хятадын 2009 оны эрчим хүчний үндсэн хэрэглээ нь ойролцоогоор 3 орчим тэрбум тн стандартын нүүрс болжээ. Тиймээс ирэх таван жилд нийт эрчим хүчний хэрэглээ 30 орчим хувиар өсөх боломжтой. Энэ нь хурдацтай үйлдвэржилт, өсөн нэмэгдэж буй хотжилтын хэрэгцээг хангахад энэхүү зорилт ихээхэн үүрэг гүйцэтгэх юм.

Нүүрс: Хятадын эрчим хүчний тулгуур

Нүүрс нь дотоодын эрчим хүчний үндсэн хэрэглээний 70 гаруй хувийг хангаж байна. Хятад улс нүүрсний хангалттай арвин нөөцтөй боловч газрын тос, байгалийн хийн нөөц багатай. Үүнтэй уялдуулан Хятадын Засгийн газар “Эрчим хүчний хөгжлийн Дунд болон Урт хугацааны төлөвлөгөөний тойм (2004-2020)”-д нүүрсийг эрчим хүчний гол эх үүсвэр хэмээн тодорхойлсон.

Хэдий тийм боловч ҮЭХУГ-ын зүгээс улс орны энэхүү нүүрснээс хэт хамааралтай байдлыг багасгах боломжийг байнга эрэлхийлж байна. ҮЭХУГ-ын дэд сайд У Инь-ий хэлснээр ирэх таван жилд салхи, цөмийн болон нарны эрчим хүчний үйлдвэрлэлийн хурдацтай хөгжил, байгалийн хий зэрэг цэвэр түлшний тогтвортой хэрэглээг боломжийн хэрээр нэмэгдүүлж, эрчим хүчний нийт зардалд нүүрсний эзлэх зардлыг бууруулах болно хэмээн мэдэгджээ. Ноён Жян Бинь-ийн тооцоогоор 2015 он гэхэд эрчим хүчний нийт зардалд нүүрсний эзэлж буй хувийг 70-аас 63-д хүргэх бололцоотой аж.

Одоогийн тооцоогоор, 2015 онд эрчим хүчний нийт зардал 4,2 тэрбум орчим тн стандарт нүүрс болохыг дээрх тооцоогоор 3,7 тэрбум тн хүртэл багасгах бололцоотой гэсэн үг юм. Өнгөрсөн 2010 онд Хятадын нүүрсний нийт хэрэгцээ 3,3 тэрбум тн байснаас 3,2 тэрбум тн дотооддоо олборлож 0,1 тэрбум тн гадаадаас импортлолсон байна. Тиймээс 2015 онд хүрэхээр зорьж буй 3,7 тэрбум тн гэдэг бол томоохон зорилт болох юм.

Эдийн засгийн хөгжлөөр тэргүүдэгч Зүүн Хятадад тавьж буй хязгаарлалт

“Секьюрити журнал” сэтгүүлд дурьдсанаар ҮЭХУГ-ын зүгээс эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлж байгаа зүүн Хятад тэр дундаа Бохайн булан, Янзе гол болон Жу мөрний гурвалжин орчмын эдийн засгийн чөлөөт бүсэд

*Шү Кеси - “China Today” сэтгүүлийн тусгай сурвалжлагч

нүүрс шатааж эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж бууруулах арга хэмжээ авах талаар анхаарах ажээ.

Товчхондоо, дараагийн таван жилийн дотор зүүн Хятадад нүүрс хэрэглэдэг цахилгаан станцуудыг багасган цөмийн болон байгалийн хий ашигладаг цахилгаан станцуудыг шинээр барьж байгуулах юм.

Улс орны дотоодод эдийн засгийн хөгжлөөрөө сүүл мушгиж буй баруун болон төвийн бүсийн хувьд аль болох усан болон байгалийн гаралтай бусад эрчим хүчний эх үүсвэрийг түлхүү ашиглах явдлыг нэмэгдүүлэх стратеги баримтлахаар болжээ. Томоохон хэмжээний дулааны цахилгаан станц (ДЦС) шинээр барьж байгуулах болон эрчим хүч дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх нь оновчтой шийдэл болно гэж үзэж байна. Баруун өмнөд бүсийн хувьд байгалийн хийн олборлолт, усны эрчим хүчийг ашиглах талаар анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн хүрээлэн буй орчинг хамгаалах болон хүн амын суурьшлын талаарх хөгжлийн тэнцвэрийг барих арга хэмжээ авахыг шаардаж байна.

Хятад улс 2011 оноос эхлэн Шаньси, Ордос, Өвөр Монголын зүүн хэсэг, Шинжаан зэрэг таван газарт иж бүрэн эрчим хүчний тулгуур төв байгуулахаар болов. Эдгээрээс гадна Төвийн бүсийн зүүн хэсэгт шинээр атомын цахилгаан станц барих ажээ. Эдгээр зургаан томоохон төв нь Хятад улсын 2030 он хүртэлх эрчим хүчний үндсэн хэрэглээг хангахад голлох үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Боловсруулаагүй газрын тосны тогтвортой хангалт болон байгалийн хийн нэмэгдсэн хэрэглээ

2011-2015 оны хооронд Хятад улс эрчим хүчний хөгжлийн хувьд долоон гол зорилт дэвшүүлснээс чулуун нүүрсний түлшний үр өгөөжтэй хэрэглээг дэмжих явдлыг хамгийн чухал хэмээн тодорхойлсон байна.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд нүүрсний уурхайн үйлдвэрлэлийг сайжруулах, нүүрсний цэвэр технологийг дэмжих, газрын тос, байгалийн хийн олборлолтыг эрчимжүүлэх, ДЦС-н хөгжлийг оновчтой болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. ҮЭХУГ-ын зүгээс түүхий газрын тос, байгалийн хийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх талаар дэмжлэг үзүүлэх ажээ.

Статистик мэдээллээр, Хятадын газрын тосны үйлдвэрлэл өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн бөгөөд цаашдаа буурах төлөв ажиглагдаж байна. Тиймээс томоохон хэмжээний газрын тосны орд газар шинээр нэмж нээгдээгүй тохиолдолд үйлдвэрлэлийн хэмжээ өснө гэж үзэхэд учир дутагдалтай. Энэхүү үзүүлэлттэй харьцуулахад, Хятадын байгалийн хийн үйлдвэрлэл ирэх таван жилд томоохон амжилтад хүрэх боломжтой.

ҮЭХУГ-ын тооцоогоор Хятадын 2010 оны байгалийн хийн үйлдвэрлэл 95 тэрбум шоо метр хүрсэн ба гадаадаас импортолсон 16 тэрбум шоо метр байгалийн хийн хамтаар нийтдээ 111 тэрбум шоо метрт хүрч дээд амжилт тогтоожээ.

Ноён Жян Бинь-ийн тооцоогоор, 2015 он гэхэд Хятадын байгалийн хийн хэрэглээ 260 тэрбум шоо метрт хүрэх бөгөөд энэ нь нийт эрчим хүчний зардалд эзлэх хувь нь 3,9-ээс 8,3 хувь хүртэл нэмэгдэх төлөвтэй ажээ.

Харин энэхүү салбарт ажиллаж байгаа хүмүүс энэ талаар арай аядуу төсөөлөлтэй байна. Тухайлбал, Хятадын Газрын тосны төлөвлөлт, инженерчлэлийн хүрээлэнгийн Газрын тос болон байгалийн хийн хоолойн хэлтсийн орлогч захирал Ян Жяньхунгийн тооцоогоор 2015 онд Хятадын байгалийн хийн хэрэглээ 200 тэрбум шоо метрийн хэмжээг давж 240 тэрбум шоо метрт хүрвэл эрчим хүчний нийт зардлын 6-7 хувь болох магадлалтай гэж тооцоолж байна.

Нүүрсэн бус түлшний хэрэглээг дэмжих нь

ҮЭХУГ-ын тооцоогоор 2020 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээний 15 хувийг нүүрсэн бус түлшнээс гаргаж авч, нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 40-45 хувиар бууруулах ба 2015 он гэхэд нүүрсэн бус түлшний хэрэглээ Хятадын эрчим хүчний нийт хэрэгцээний 11 хувийг эзлэх ажээ.

Чулуун нүүрсэн түлшний хамгийн гол өрсөлдөгч болох усан цахилгаан станц нь Хятадын хий ялгаруулалтыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд хамгийн гол үүрэг гүйцэтгэнэ. Хятад улсын хувьд 2010 он одоогийн суурилуулсан усан цахилгаан станцын үйлдвэрлэлийн хүчин чадал нь 200 сая квт-д хүрсэн түүхэн тэмдэглэлт үйл явдал боллоо. Ирэх таван жил ч гэсэн усан цахилгаан станцын (УЦС) үйлдвэрлэлийн томоохон хөгжлийн жил байх болно гэж үзэж байна. Жянь Бингийн үзэж байгаагаар 2015 он гэхэд одоогийн суурилуулсан УЦС-ын хүчин чадлыг 250 сая квт болгон өргөжүүлэх боломжтой юм.

Хятадын одоогийн суурилуулсан нийт цахилгаан станцын хүчин чадлыг 2015 он гэхэд 1,43 тэрбум квт-д хүргэхээр төлөвлөж байна. Үндэсний эрчим хүчний судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгч Жан Юньжуны тооцоолсноор энэ нь 2010-2015 оны хооронд нэмж 400 сая квт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрлэл байгуулах шаардлагатайгаас 100 сая-ыг УЦС, 36 саяыг цөмийн цахилгаан станц, 68 саяыг салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангана гэж үзжээ.

Жянь Бингийн таамаглаж байгаагаар 2015 он гэхэд Хятад улс 39 сая квт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай дэлхийд хамгийн том цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлтэй болох ажээ.

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хятадын салхины эрчим хүчний үйлдвэрлэл олон дахин нэмэгдсэн ба одоо ч гэсэн хамгийн өндөр хөгжлийн хурдацаа хадгалсаар байна. Өнөөдөр Хятад улс энэ чиглэлийн үйлдвэрлэлээрээ АНУ-ыг аль хэдийнэ гүйцэж түрүүлсэн бөгөөд дэлхийд тэргүүн байрыг эзэлж байна. Энэ салбарт ажиллаж байгаа олон тооны мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар 2020 он гэхэд хятадад суурилуулсан салхины эрчим хүчний үйлдвэрлэлийн чадал 300 сая киловатт хүрнэ гэж үзэж байна. Энэ нь ҮЭХУГ-аас гаргасан 2010 оны статистик мэдээлэлд дээрх үзүүлэлт 35 сая киловатт байсан бөгөөд энэ нь ирэх 10 жилийн хугацаанд 8 дахин өснө гэсэн үг юм.

2010 онд төрийн зүгээс нарны эрчим хүч ашиглах талаар томоохон тендерүүд зарлагдаж эхэлсэн учраас улсын хэмжээнд 2011-2015 он нарны

эрчим хүч ашиглан эрчим хүч үйлдвэрлэх явдал үсрэнгүй хөгжлийн жил байх болно гэж үзэж байна.

Эрчим хүчний хэмнэлт ба хүрээлэн буй орчинд үзүүлэх бохирдлын хэмжээг бууруулах

Цахилгаан эрчим хүч гаргаж авах илүү цэвэр аюулгүй арга зам эрэлхийлэх хажуугаар ҮЭХУГ-ын зүгээс эрчим хүчний хэрэглээний хэмнэлтийн талд ихээхэн ач холбогдол өгч цахилгаан хэрэглээний үр өгөөжийг нэмэгдүүлэх нь гол арга зам юм хэмээн тодорхойлж байна.

Эрчим хүчний хэмнэлт бол Хятадын эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд ноён У Инь “Зөвхөн эрчим хүчний хэмнэлт Хятад улсын тогтвортой хөгжлийг хангаж чадна” хэмээн тэмдэглэв.

Өнгөрсөн 2010 онд Хятад улс эдийн засгийн хөгжлөөрөө Японыг гүйцэн түрүүлж дэлхийн хоёр дахь том эдийн засагтай улс болсон хэдий ч хамгийн их санаа зовоож буй баримт бол хэдийгээр бараг ижил түвшний ДНБ-тэй болохоор хичээж буй энэ үед Хятадын эрчим хүчний зардал Японоос 4,6 дахин өндөр гарч байна. Ноён У Инь “Манай иргэдийн эрчим хүчний хэрэглээ нь дэлхийн дундаж түвшингээс доогуур, өндөр хөгжилтэй улсуудын түвшингээс хоёр дахин бага, АНУ-ын иргэдийн хэрэглээний дөнгөж дөрөвний нэг хувьтай тэнцэж байна. Хэрвээ хэзээ нэгэн цагт манай хятад иргэдийн эрчим хүчний хэрэглээ АНУ-ын түвшинд хүрэхэд, бид дэлхий дээрх эрчим хүчний 80 хувийг дангаараа хэрэглэдэг болох магадлалтай” гэж анхааруулав.

Эрчим хүчийг хэрхэн хэмнэх вэ? Үүний тулд үндсэн хэрэгцээг хүрэлцэхүйцээр хангаж, хэтэрсэн хэрэглээнд хязгаар тогтоож, хэмнэлтийг урамшуулах зэргийг эрчим хүчний менежментийн чиглэлд тусгаж өгөх нь зүйтэй ноён У Инь илтэж байна.

Ноён У энэ талаар жишээ татан тайлбарлахдаа “Саяхан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос ард иргэдийн дунд хувийн хэрэглээний эрчим хүчний төлбөрийн асуудлаар явуулсан санал асуулгын дүнд цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нь хэмнэлтийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой гэж гарсан байна. Үйлдвэрлэлийн салбарын хувьд үйлдвэр аж ахуйн нэгж бүр цахилгаан хэрэглээний үрэлгэн байдлыг хазаарлан зогсоох зорилгоор хатуу чанга стандарт хэрэгжүүлж эхэлсэн.” гэжээ.

Ноён Жян Бин ҮЭХУГ-ын зүгээс эрчим хүчний үйлдвэрлэл болон хэрэглээний бүхий л үйл ажиллагаанд цахилгааны хэмнэлт, бохирдлын хэмжээг бууруулах талаар цаашид ч гэсэн анхаарал тавин ажиллах болно гэжээ. Үр өгөөжтэй эрчим хүчний үйлдвэрлэл, дэвшилтэт эрчим хүчний хангамжийн менежментийг баттай болгосноор тэнцвэртэй хөгжлийг бий болгоход чармайн ажиллах болно.

2011-2015 оны Хятадын эрчим хүчний хөгжлийн тэргүүлэх долоон зорилт

1. Чулуун нүүрсэн эрчим хүчний үр өгөөжтэй хэрэглээг хөхиүлэн дэмжих

2. Чулуун нүүрсэн бус эрчим хүчний эх үүсвэрийн хөгжлийг түргэсгэх
3. Хятад улсын хэмжээнд эрчим хүч дамжуулах сүлжээний байгууламжийг сайжруулж, түгээлтийн сүлжээг сайжруулах
4. Шинэ эрчим хүчний технологийн хөгжил болон хэрэглээг түргэтгэх
5. Эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалтын үеийн хэмнэлт болон бохирдлыг бууруулах
6. Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх
7. Эрчим хүчний системийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх

Эх сурвалж: “China Today” сэтгүүлийн 2011 оны 1-р дугаар болон цахим хувийг http://www.chinatoday.com.cn/ctenglish/se/txt/2011-01/10/content_323995.htm -аас үзнэ үү.

Англи хэлнээс орчуулсан Д.Золбоо (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр)